



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/156

Шивээговь сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1."Нэртийн хурд-2023" Говьсүмбэр аймгийн дээд 4 насны хаврын бүсийн уралдаанд зориулж, "Нэртийн хурд" уяачдын холбоонд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Тус арга хэмжээнд зарцуулагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг "Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлт 210901"-с зохих журмын дагуу гаргаж, баримт бичгийн бүрдлийг ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа), нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), зарцуулсан төсөв санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж, тайланг гаргаж ирүүлэхийг "Нэртийн хурд" морин спорт уяачдын холбооны тэргүүн А.Нямхүү нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ

